

“Өөсөө төрсөн ухаан нэрт хааны тууж” зохиолд өгүүлсэн өвчний шалтгааны үзлийг “Анагаах ухааны дөрвөн үндэс” болон түүний тайлбар зохиолтой харьцуулах нь

Алтанхуяг Г.¹, Мягмардаш Б.², Анхцацрал Л.³, Наранзаяа Л.³, Цэвээндарь Н.⁴, Энхсайхан Д.⁴, Шагдарсүрэн Д.¹, Болд Ш.^{1,3}, Цэцэгдарь Т.¹

¹Эм зүйн шинжлэх ухааны их сургууль

²Этүгэн Их Сургууль

³“Ач” Анагаах ухааны их сургууль

⁴Монос Улаанбаатар, Монос ХХК

Цахим хаяг: tsetsegdari.t@monos.mn

Abstract

A Comparative Study of Disease Causation in “Öösöö törsön ukhaan nert khanii tuuj” and the Four Medical Tantras with Their Commentarial Traditions

Altankhuyag G.¹, Myagmardash B.², Ankhtsatsral L.³, Naranzaya L.³, Tseveendari N.⁴, Enkhsaikhan D.⁴, Shagdarsuren D.¹, Bold Sh.^{1,3}, Tsetsegdari T.¹

¹Mongolian University of Pharmaceutical Sciences

²“Etugen” University

³“Ach” Medical University

⁴Monos Ulaanbaatar, Monos LLC

E-mail: tsetsegdari.t@monos.mn

Introduction

In traditional medicine, theories concerning the causes of disease have historically developed in close association with Buddhist philosophical thought. This interrelationship is consistently reflected in the works of prominent physicians and scholars from India, Tibet, and Mongolia. Öösöö törsön ukhaan nert khanii tuuj by Undur Gegeen Zanabazar presents disease causation through symbolic and narrative expressions. A comparative examination of this work alongside classical medical treatises provides a conceptual framework for understanding the integration of philosophical doctrine and medical theory.

Goal

The objective of this study is to comparatively examine the concept of disease causation articulated in Öösöö törsön ukhaan nert khanii tuuj and the explanations presented in the classical texts Four Medical Tantras and Altan Khadmal.

Materials and Methods

The primary materials for this study consist of Öösöö törsön ukhaan nert khanii tuuj by Undur Gegeen Zanabazar and foundational classical texts of traditional medicine. The research employs an integrated methodological approach combining source criticism, hermeneutic analysis, comparative methods, and analysis–synthesis. Key terms, semantic meanings, and symbolic narratives within the selected sources were systematically analyzed and compared.

Results

The results demonstrate that the symbolic depictions of ignorance, anger, and desire in Öösöö törsön ukhaan nert khanii tuuj are conceptually consistent with the theory of distant (root) causes of disease as described in classical traditional medical texts. While classical medical texts articulate disease causation through structured philosophical and logical frameworks, the narrative form of the tuuj conveys equivalent theoretical content through imagery and symbolism, thereby enhancing conceptual accessibility.

These findings suggest that Undur Gegeen Zanabazar's teachings constitute a comprehensive intellectual system integrating Buddhist philosophy, religious doctrine, and the theoretical foundations of traditional medicine. Symbolic narrative thus emerges as a coherent and effective mode for transmitting medical knowledge within the broader traditional epistemological context.

Keywords: Classical Medical Texts; Disease Causation; Traditional Medicine;

Pp. 62-67, References 15

Оршил

Уламжлалт анагаах ухаан нь буддын шашны таван их ухааны нэг бөгөөд өвчний шалтгааны тухай онол нь буддын гүн ухааны онолтой холбогддогийг Энэтхэг, Төвд, Монголын алдарт эмч маарамбууд өөр өөрийн бүтээлүүдээрээ илэрхийлсээр ирсэн [1,2] нь Буддын гүн ухаан болон Уламжлалт анагаах ухаан салшгүй нэг ойлголт гэдгийг харуулж байна.

Уламжлалт анагаах ухааны гол сурвалж бичиг болох “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ний Номлолын үндэсний тайлбар “Алтан хадмал” зохиолд мянга зургаан зуун арван зургаан өвчин байна гэж бичсэн бөгөөд өвчний холын шалтгаан нь ойрын шалтгаанд нөлөөлсөн 404 өвчин байна гэжээ.

“Анагаах ухааны дөрвөн үндэс”-ний “Номлолын үндэс”-ний өвчний шалтгааныг үзүүлсэн 8-р бүлэгт “Тиймийн тул хамаг өвчний ерийн шалтгааныг өгүүлэхүй нь, хамаг өвчин нүгүүдийн гагц шалтгаан нь би үгүйн утгыг эс оносноор мунхаг хэмээхүй. Үлгэрлэвээс, шувуу огторгуйд нисэвч өөрийн сүүдэр түүн лүгээ үл хагацах мэт. Хамаг амьтан амгаланд оршин явавч мунхаг буйн тул өвчнөөс үл хагацъяу. Ялгалын шалтгаан нь мунхагас болсон тачаангуй, урин, мунхаг гурван хороос тачаангуй нь хийн гэм, урин нь шарын

гэм, мунхаг нь бадганы гэмийг үүсгэмүй. Өвчний ойрын шалтгаан болох нь хий, шар, бадган гурвуул машид эс урваваас өвчний шалтгаан төдий бөгөөд урваж үл тэгшдэхүйд өвчний мөн чанар болж, бие хийгээд аминд хорлож эмгэнүүлэхүй буй” [3,4] хэмээсэн байдаг.

Мөн өвчний шалтгааны талаарх Ведийн өмнөх үеийн домогт “Газар дэлхий дээр хүн төрөлхтөн анхан үүсэж байх үед Шидвү хэмээх нь хүний оронд анх төржээ. Шим ертөнцийн хоол хүнс барагдаж буйг ажиглаад ховдог шуналын сэтгэлийн эрхээр хоргуус тэргүүтэн идээнд тачаадан идэх шунал төрч идсэнээр анхны эс шингэсэн өвчин үүссэн” [5,6] гэж өгүүлжээ. Үүнээс харвал Ведийн өмнөх үеийн хүний үүсэл хөгжлийг харуулсан домог зохиолд өвчний хол ойрын шалтгааныг үзүүлсэн байгаа нь хүн төрөлхтөнд домог зүйгээр сэтгэл хийгээд өвчний хол ойрын шалтгааныг таниулан сургадаг байсан нь харагдаж байна.

Мөн Өндөр гэгээн Занабазарын соёмбо үсгээр бичсэн “Өөсөө төрсөн ухаан нэрт хааны тууж” зохиолд өвчний шалтгааныг шүлэглэн өгүүлсэн байдаг бөгөөд тэрхүү агуулгыг АУ-ы тайлбар зохиолуудтай харьцуулан судалж биеийн өвчин эмгэг нь өөрийн сэтгэлээс төрдөг гэдгийг гаргаж ирэх нь уг судалгааны ажлын үндэслэл болно.

Зорилго:

“Өөсөө төрсөн ухаан нэрт хааны тууж” зохиолд өгүүлсэн өвчний шалтгааны үзэл болон “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Алтан хадмал” зохиолуудын өвчний шалтгааны тайлбаруудыг харьцуулан дүгнэх.

Материал

Үндсэн хэрэглэгдэхүүн:

Өндөр гэгээн Занабазарын “Өөсөө төрсөн ухаан нэрт хааны тууж” [7]

Нэмэлт хэрэглэгдэхүүн:

“Анагаах ухааны дөрвөн үндэс” [3]

Дармо маарамба Лувсанчойдог “Алтан хадмал” [4]

Арга зүй

Судалгаанд сурвалж бичиг судлалын арга, герменевтик тайлбарлах арга, харьцуулах судалгааны арга, анализ–синтезийн аргуудыг цогцоор нь ашиглав.

Юуны өмнө сонгон авсан сурвалж бичгүүдэд эх сурвалжийн шүүлт хийж, түүхэн уламжлал, бүтэц, хэрэглэгдэх нэр томъёог үнэлэхийн тулд сурвалж бичиг судлалын арга [8]-ыг мөрдөв.

Текстийн нэр томъёо, үгийн утга, далд агуулга, бэлгэдлийн бүтцийг тайлбарлахдаа герменевтикийн онолын үндэслэлд тулгуурласан [9, 10].

Харин уламжлалт болон орчин үеийн эх сурвалжуудын мэдээллийг харьцуулан шинжлэхдээ харьцуулах аргыг [8] болон анализ–синтезийн [11] зарчимд тулгуурлав.

Ийнхүү сурвалж бичиг, философи, герменевтик болон логик-арга зүйн суурь зарчмуудыг хослуулан ашигласнаар судалгааны сурвалжуудын ил ба далд агуулгыг бүрэн задлан шинжилж, харьцуулалт хийх боломж бүрдэв.

Судалгааны арга зүйг ЭЗШУИС-ийн Нэгдсэн эрдмийн зөвлөлийн 2025 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан болно.

Үр дүн

Уламжлалт анагаах ухаанд өвчний шалтгааныг тайлбарлахдаа онолын системчилсэн тайлбар болон бэлгэдэл, өгүүлэмжийн хэлбэрийг хослуулан хэрэглэж ирсэн уламжлал ажиглагддаг. Судрын онолын тайлбар нь өвчний язгуур шалтгааныг философи, логикийн түвшинд тодорхойлдог бол илбэ, домог, өгүүлэмж, бэлгэдлийн хэл нь эдгээр ойлголтыг өргөн хүрээний уншигч, сонсогчдод ойлгомжтой байдлаар дамжуулах үүрэг гүйцэтгэж иржээ.

“Өөсөө төрсөн ухаан нэрт хааны тууж” зохиолд өгүүлсэн өвчний шалтгааны үзэл болон уламжлалт анагаах ухааны гол сурвалж бичгүүд болох “Анагаах ухааны дөрвөн үндэс”, түүний тайлбар зохиол “Алтан хадмал”-д тусгагдсан өвчний шалтгааны тайлбаруудыг харьцуулан шинжиллээ.

“Өөсөө төрсөн ухаан нэрт хааны тууж” зохиолд илбэ, өгүүлэмж, дүрүүдээр дамжуулан хүний сэтгэлийн төлөв, нисваанисыг уран бэлгэдлийн хэлбэрээр илэрхийлсэн байдаг. Харин “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Алтан хадмал” зэрэг сурвалж бичгүүдэд өвчний шалтгааныг онолын түвшинд тодорхойлж, сэтгэлийн төлөвүүд болон бие махбодын хямралын хоорондын шүтэн барилдлагыг нарийвчлан тайлбарласан байна. Эдгээр хоёр өөр илэрхийллийн хэлбэр нь агуулгын хувьд хоорондоо уялдаа холбоотой болох нь харьцуулалтаар тодорхойлогдлоо.

Уламжлалт анагаах ухаанд өвчний шалтгааныг зөвхөн бие махбодын түвшинд авч үзэхгүй, харин сэтгэлийн гүн шалтгаантай холбон тайлбарладаг байна. “Анагаах ухааны дөрвөн үндэс”-т өвчний ерөнхий, холын шалтгааныг “бие үгүй утгыг эс оносон мунхаг сэтгэл” хэмээн тодорхойлж, үүнээс үүдэн тачаангуй, урин, мунхаг хэмээх сэтгэлийн гурван хор төрж, улмаар ойрын шалтгаан болох хий, шар, бадган үүсэж өвчин бий болдог гэж үздэг. Энэ онолын тогтолцоо нь өвчин бол гадаад хүчин зүйлээс гадна дотоод ухамсрын

гажуудлын үр дагавар болохыг илэрхийлж байна.

“Өөсөө төрсөн ухаан нэрт хааны тууж”-д гарч буй “Мунхаг нэрт охин” хэмээх дүр нь бие үгүй утгыг эс оносон мунхаг сэтгэлийг төлөөлөх бөгөөд энэ нь өвчний язгуур, ерөнхий шалтгаан болдог тухай судрын сургаалтай агуулгын хувьд бүрэн дүйж байна. Мунхаг сэтгэл нь хоосон чанарыг үл ухаарах, “би” хэмээх үзэлд баригдах байдлаар илэрч, үүнээс үйлийн үр хуримтлагдан өвчин зовлон тасралтгүй үүсэх шалтгаан болдог тухай тайлбарууд “Алтан хадмал” болон бусад тайлбар зохиолуудад давтан нотлогдсон байдаг.

Үүнтэй адилаар “Тачаагч нэрт охин” нь тачаангуй буюу хүсэл шуналд автах сэтгэлийг бэлгэдсэн дүр юм. Уламжлалт анагаах ухаанд тачаангуй сэтгэл нь хий өвчний холын шалтгаан болдог хэмээн тайлбарладаг бөгөөд хүсэл шунал нь сэтгэлийг тогтворгүй болгож, хөдөлгөөн чанарыг ихэсгэн, хий арвижих нөхцөлийг бүрдүүлдэг гэж үздэг. Энэхүү онолын тайлбар нь тууж дахь “Тачаагч” хэмээх дүрийн утга агуулгатай шууд уялдаж байна.

Мөн уур хилэн, атаа хорсолд автах сэтгэлийг илэрхийлсэн дүрүүд нь судрын тайлбар дахь урин буюу уур хилэнгийн ойлголттой дүйж, шар өвчний холын шалтгааныг төлөөлдөг. Уламжлалт анагаах ухаанд уур хилэн нь элэг, цөсийг хямралдуулж, халуун чанарын өвчнийг үүсгэдэг гэж тайлбарладаг нь илбэ–өгүүлэмж дэх уурын шинжтэй дүрүүдийн үйлдэл, үр дагавартай агуулгын хувьд нийцэж байна.

Илбэ, илбэч, илбийн үйл хэмээх ойлголтуудыг судрын онолын тайлбартай харьцуулан үзэхэд, эдгээр нь ид шид, ер бусын чадварыг илэрхийлсэн бус, харин хүний сэтгэлийн төөрөгдөл, нисваанисыг бодит мэтээр ойлгож, түүнд автах үйл явцыг бэлгэдсэн нэршил болох нь тодорхой харагдаж байна. Өөрөөр хэлбэл, илбэ нь өвчний жинхэнэ эх сурвалж болох сэтгэлийн гажуудлыг уран дүрслэлээр илэрхийлсэн хэлбэр юм.

Ийнхүү “Өөсөө төрсөн ухаан нэрт хааны тууж”-д өгүүлсэн илбэ–бэлгэдлийн өгүүлэмжүүд нь “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Алтан хадмал” зэрэг уламжлалт анагаах ухааны сурвалж бичгүүдэд тайлбарласан өвчний шалтгааны онолтой зөрчилдөхгүй, харин ч тэдгээрийн утга агуулгыг ойлгуулах, ухамсарт ойртуулах үүрэгтэй илэрхийллийн хэлбэр болох нь энэхүү харьцуулалтаар тодорхой болж байна. Судрын онол нь өвчний шалтгааныг философи, логикийн түвшинд системчилсэн бол илбэ–өгүүлэмж нь түүнийг дүр, бэлгэдэл, өгүүлэмжээр дамжуулан ойлгомжтой хэлбэрт оруулсан уламжлалт тайлбарын нэг хэлбэр хэмээн бид үзлээ.

Хэлцэмж

Монголын уламжлалт анагаах ухаан, буддын гүн ухааны огтлолцол дээр “өөсөө төрсөн” хэмээх ойлголтыг онолын түвшинд тайлбарласан чухал бүтээлүүдийн нэг нь Богдын хүрээний хамба, гүн ухаантан Агваанхайдав [12] (1779–1838)-ын зохиолууд юм. Тэр бээр “өөсөө төрсөн” гэх нэр томъёог уламжлалт анагаах ухааны онолын үндэс болох таван махбодын сургаал, мөн бие тогтох ёсны “тийн мэдэл” хэмээх ойлголттой уялдуулан тайлбарласан нь хүний бие, сэтгэл, махбодын шүтэн барилдлагыг гүнзгийрүүлэн ойлгоход чиглэсэн онолын чухал суурь болж байна.

Энэхүү үзэл санаа нь Монголын анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазар Жавзандамба хутагтын айлдсан “Өөсөө төрсөн ухаан нэрт хааны тууж”-д илүү өргөн хүрээтэй, сургаалын хэлбэрээр илэрхийлэгдсэн байдаг. Уг тууж нь бүтцийн хувьд дээдийн ном Монгол оронд дэлгэрсэн түүхэн удиртгал, илбэдүүлсэн буюу мунхагт автагдсан үеийн байдал, улмаар илбээс сэргэж ухааралд хүрэх үе шат гэсэн дараалалтайгаар өгүүлэгдсэн нь хүний сэтгэлийн гажуудал, түүний үр дагаврыг шаталсан байдлаар харуулж байна.

Анагаах ухааны үүднээс авч үзвэл “Өөсөө төрсөн ухаан нэрт хааны тууж”-д өвчний

ерөнхий шалтгаан, өвчний холын шалтгаан, эрдэм боловсролыг эрүүл энхийн үндэс хэмээн үзэх ойлголт, бие тогтох ба эвдрэх ёсны “үйлийн” мөн чанар, зүүдний онол зэрэг онолын болон эмнэлзүйн чухал асуудлууд багтсан байна. Энэ нь өвчин эмгэгийг зөвхөн бие махбодын түвшинд бус, сэтгэл–оюун–үйл хэмээх олон түвшний шүтэн барилдлагын хүрээнд ойлгох уламжлалт анагаах ухааны хандлагыг тод томруунаар илэрхийлж байна.

Эдгээр уламжлалт сургаал, тайлбарууд нь орчин үеийн шинжлэх ухааны судалгааны үр дүнтэй тодорхой хэмжээгээр нийцэж байгааг харуулж болно. Тухайлбал, уур бухимдал, архаг стресс нь хүний сэтгэлзүй болон зүрх судасны тогтолцоонд сөрөг нөлөө үзүүлдгийг орчин үеийн судалгаагаар тогтоосон байдаг [13]. Мөн шунал, хэт хүсэл нь нийгмийн харилцааг хүндрүүлж, стрессийг нэмэгдүүлснээр сэтгэцийн эрүүл мэнд, цаашлаад бие физиологийн үйл ажиллагаанд нөлөөлөх боломжтойг судалсан байна [14].

Харин уламжлалт анагаах ухаанд “мунхаг” хэмээн нэрлэдэг ойлголтыг орчин үеийн судалгаанд шууд хэмжихэд төвөгтэй боловч үүнийг эрүүл мэндийн боловсрол (health literacy)-ын дутмаг байдалтай дүйцүүлэн тайлбарлаж болох юм гэж үзлээ. Эрүүл мэндийн боловсрол муутай, уншиж бичих чадвар сул хүмүүс эмнэлгийн тусламжийг илүү олон удаа авах, эрүүл мэндийн байдал нь харьцангуй дор байх хандлагатайг судалгаагаар харуулсан нь энэ ойлголтыг орчин үеийн нөхцөлд тайлбарлах боломжийг нээж байна [15].

Иймд уламжлалт анагаах ухааны сургаалд өгүүлсэн мунхаг, уур, шунал зэрэг сэтгэлийн төлөв байдал нь хүний бие физиологид нөлөөлөн өвчин эмгэг үүсэх суурь нөхцөл болдог гэсэн ойлголт нь орчин үеийн судалгааны дүнтэй зарчмын хувьд зөрчилдөхгүй байна. Энэ нь уламжлалт анагаах ухааны онолын суурийг орчин үеийн шинжлэх ухааны судалгаатай уялдуулан цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатайг харуулж байна.

Дүгнэлт

“Өөсөө төрсөн ухаан нэрт хааны тууж”-д бэлгэдлийн хэлбэрээр өгүүлсэн мунхаг, уур, тачаалын үзэл санаа нь уламжлалт анагаах ухааны сурвалж бичгүүдэд өвчний холын шалтгаан хэмээн тодорхойлсон онолтой агуулга, утгын хувьд бүрэн нийцэж байгааг бөгөөд энэхүү уялдаа холбоо нь Өндөр гэгээн Занабазарын сургаал нь зөвхөн шашин, гүн ухааны бус, анагаах ухааны онолын үндэстэй нягт холбогдсон цогц мэдлэгийн илэрхийлэл болохыг нотолж байна.

Ном зүй

1. Шагдарсүрэн Д. “Буддын гүн ухаан ба өвчний ерийн шалтгаан”, Гандан тэгчилэн хийдийн дэргэдэх “Сутра” хэвлэлийн үйлдвэр, 2006. х.10.11
2. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006. х.307.
3. “Анагаах ухааны дөрвөн үндэс”, Үндэсний хэвлэлийн хороо, 1991., х91
4. Дармо маарамба Лувсанчойдог. “Алтан хадмал” тайлбар зохиол, уйгаржин бичгээр, ӨМӨЗО, 1988.х.152-208
5. Лүнрэг Дандар. “Монголын уламжлалт анагаах ухааны түүх”, Улаанбаатар, 1993. х.9
6. Цэнд-Аюуш Д. “Уламжлалт анагаах ухааны онолын үндэс”, Улаанбаатар, 2013. х.60-63
7. Өндөр гэгээн Занабазарын зохиосон “Өөсөө төрсөн ухаан нэрт хааны тууж”-н талаарх Р. Отгонбаатар, А.Д. Цендина нарийн “Монгол үсэг бичгийн дээж” бүтээл дэх судалгааны өгүүлэл, 2012, х.1-15
8. Лодой Г. Шинжлэх ухааны судалгааны логик-арга зүйн асуудлууд. Улаанбаатар. 2012. х.54-62
9. Dilthey W. Introduction to the Human Sciences. Princeton University Press. 1989. p.78

10. Gadamer H.-G. Truth and Method. Continuum Publishing. 2004.p.179-201
11. Bacon F. Novum Organum. Cambridge University Press. 1620. p.95-110
12. Агваанхайдав “Сэтгэл бусдын тус ямагтыг ямар мэт үйлдэж байсны цадиг өлөг, мэдэл, төгс бус хуран үйлдэгч гурвын зөвшилцөөнөөс үүдсэн солиролын дууриал бүжиглэлийг тодруулан үйлдэгч толь оршвой” /1779-1839/
13. Chida Y, Steptoe A. The association of anger and hostility with future coronary heart disease: a meta-analytic review of prospective evidence. J Am Coll Cardiol. 2009;53(11):936–46. Available from: <https://pubmed.ncbi.nlm.nih.gov/19281923>
14. Wei S. Greed personality trait links to negative psychopathology and underlying neural substrates. Front Psychol. 2022;13:1003687. Available from: <https://pmc.ncbi.nlm.nih.gov/articles/PMC10036871>
15. DeWalt DA, Berkman ND, Sheridan S, Lohr KN, Pignone MP. Literacy and health outcomes. J Gen Intern Med. 2004;19(12):1228–39. Available from: <https://pmc.ncbi.nlm.nih.gov/articles/PMC1492599>

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Академич Ч.Чимэдрагчаа*